

УЛС ТӨР,
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**НАЙРАМДАЛТ
МОНГОЛ, ЭНЭТХЭГИЙН
ХАРИЛЦАА,
АЗИД ЭНХ ТАЙВАН,
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ АСУУДАЛ**

Д. ПҮРЭВ

Нийгмийн янз бүрийн байгууламж бүхий дэлхийн улс орнуудын хүн амын гуравны хоёр нь оршин суудаг Ази тивд энх тайван, тогтвортой байдлыг хангах явдал зөвхөн Азийн төдийгүй орчин үеийн олон улсын харилцааны тулгамдсан асуудал болж байна.

Дэлхийн II дайнд Зөвлөлтийн зэвсэгт хүчин, ард түмний шийдвэрлэх тэмцлийн үр дүнд Гитлерийн фашизм, Японы милитаризмыг бутцохисноор дэлхийн хүчний харьцаанд ардчилал, социализм давамгайлах болж, үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж байсан Колони, хараат орнуудын ард түмэн харийн дарлалаас эгнэгт ангижирч Азийн тусгаар тогтносон улсуудын хооронд шинэ маягийн харилцааны үндэс тавигдсан билээ.

БНМАУ өөрийн социалист төрийн энх тайванч гадаад бодлогын үндсэн зарчмыг мөрдлөг болгож нийгмийн өөр өөр байгууламжтай улсуудтай энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр найрсаг харилцаа тогтоон хөгжүүлэх талаар тууштай байр суурь баримтлан¹ шинэ тулгар тусгаар тогтносон Ази, Африкийн улсуудад баяр хүргэсэн юм.

БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох хүсэл эрмэлзлэлээ илэрхийлсэн социалист биш анхны улс бол Ази тивийн эртний түүх, соёлын гайхамшигт уламжлалтай Энэтхэг билээ. Улс төрийн тусгаар тогтнолоо байлдан олж авсан тэр цагаас эхлээд Энэтхэг улс өөрийн хөрш зэргэл дээ улсууд, Ази тивийн бусад орнуудтай найрсаг харилцаа тогтоон үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, энэ тивийн чөлөөлөгдсөн ард түмний нийтлэг хүсэл эрмэлзлэлийг мөрдлөг болгон империализм, колонилол, шинэ колонилолын бодлогын эсрэг зохион байгуулалттай хамтын тэмцэл өрнүүлэх асуудалд онцгой анхаарч байлаа. Үүнтэй холбогдуулан Энэтхэгийн ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагчдын нэг, тусгаар тогтносон Энэтхэг улсын анхны ерөнхий сайд Жавахарлал Неругээс Ази тивийн ард түмэн эрх чөлөө тусгаар тогтнолоо олж буй үйл явцыг хуучин хана хэрэм нуран унаж, дарлагдсан ард түмэн сайн анд нөхдийн ёсоор учран золгох боллоо гэж дүгнэн хэлж байв.

Азийн ард түмнээс империализм, колонилолын эсрэг явуулж байсан тэмцлийн зохион байгуулалтын нэгдлийг хангах болон Азийн улсуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагааны асуудалд Энэтхэг улсын засгийн газар чухал ач холбогдол өгдөг юм.

Энэтхэгийн засгийн газар БНХАУ-ыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосныхоо дараа Энэтхэг, Хятадын харилцааны нарийн түвэгтэй асуудлын нэг болж байсан Төвдийн талаар Хятадын засгийн газартай хэлэлцээ хийж Төвдийг БНХАУ-ын нутаг дэвсгэрийн хэсэг хэмээн хүлээн зөвшөөрч улмаар Энэтхэг, Хятадын харилцааны үндсэн зарчим «Панча шила»-г тунхаглаж, хөрш зэргэлдээ улсуудтайгаа энх

¹ БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. т. 1. 1964, 7—8-р талд.

тайвнаар зэрэгцэн орших «Панча шила»-ийн үндсэн дээр найрсаг харилцаа тогтоон хөгжүүлж эхэлсэн юм.

Энэтхэг улс Ази Африкийн 29 орны төр, засгийн газрын тэргүүн нарын Бандунгийн бага хурлыг зарлан хуралдуулах асуудлыг анх үүсгэн санаачлагч орнуудын нэг мөний хувьд хурлын зохион байгуулалтын бэлтгэлийг хангах, улмаар Бандунгийн арван зарчмыг зарлан тунхаглахад идэвхтэй оролцсон юм.

Нийгмийн өөр өөр байгууламж бүхий улс орнууд Бандунгийн үзэл санааны үндсэн дээр харилцаа тогтоон империализм, колоницлолын бодлогын эсрэг явуулах тэмцлийн үйл ажиллагаагаа нэгтгэн зохион байгуулах үндсийг тавьсанд Бандунгийн бага хурлын түүхэн ач холбогдол орших бөгөөд орчин үед Бандунгийн зарчмууд нь нийгэм, улс төрийн янз бүрийн байгууламж бүхий улс орнуудын харилцааны түгээмэл хэрэглүүр болсон байна.

БНМАУ-ын Засгийн газар Бандунгийн бага хурлаас гаргасан баримт бичгийн үзэл санааг дэмжиж байгаагаар албан ёсоор мэдэгдэж² цаашдаа энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр Ази, Африкийн улсуудтай албан ёсны харилцаа тогтоон хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлээ дахин илэрхийлсэн юм.

Ази тивийн нөлөө бүхий том улс Энэтхэг БНМАУ-ын олон улсын байр суурийг тууштай дэмжиж байдгийн нэг тодорхой жишээ бол Энэтхэгийн Засгийн газар БНМАУ-тай албан ёсны харилцаа тогтоохоор шийдвэрлэсэн явдал юм.

1955 оны 12-р сард НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн ээлжит хуралдаан дээр БНМАУ НҮБ-ын гишүүн болох асуудал яригдах үеэр өрнөдийн капиталист орнууд, Чан Кайшигийн бүлэг Монголын Засгийн газрын хүсэлтэнд дахин хориг тавьснаас хэдхэн хоногийн дараа 1955 оны 12-р сарын 24-нд БНМАУ, БНЭУ-ын хооронд дипломат харилцаа тогтсон юм³. Энэ нь Монгол, Энэтхэгийн ард түмний хэлхээ холбоог шинэ нөхцөл байдалд дахин сэргээсэн төдийгүй Азийн улс түмний хоорондын харилцааг энх тайвнаар зэрэгцэн орших «Панча шила»-ийн үндсэн дээр хөгжүүлэх, үр ашигтай хамтын ажиллагааны үндэс суурийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм. Манай Улсын талаар хавчин гадуурхах бодлогыг олон жилийн туршид баримталж, тус улсыг олон улсын нэр хүнд бүхий түгээмэл байгууллагад гишүүнийхээ эрхийг эдлэхэд саад бэрхшээл учруулсаар ирсэн Өрнөдийн гүрнүүд, Тайвань дахь Чан Кайшигийн бүлгийнхэнд БНМАУ-тай албан ёсны харилцаа тогтоох талаар Энэтхэг улсын баримталсан байр суурь томоохон цохилт болж, БНМАУ, Ази, Африкийн шинэ тулгар тогтносон залуу улсуудын хооронд тэгш эрх, харилцан бие биеэ хүндэтгэх, дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчимд тулгуурласан найрсаг харилцаа, хамтын ажиллагааг тогтоон хөгжүүлэх талаар манай улсын гадаад бодлогын чухал зорилтыг хэрэгжүүлэхэд бодит түлхэц болсон билээ. БНМАУ Энэтхэг улстай дипломат харилцаа тогтоосныхоо дараа Бандунгийн бага хурлыг хуралдуулахад идэвхтэй оролцсон Индонез, Бирм зэрэг улсуудтай албан ёсны харилцаа тогтоон Ази, даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахын төлөө тэдгээр орны ард түмэнтэй нэгэн

² БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл боть I. УБ. 1964, 126-р тал

³ БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхэтгэл боть I. 1964. 15-р тал.

эгнээнд явж социалист төрийн гадаад бодлогынхоо зорилтыг амжилттай хэрэгжүүлж, олон улсын үйл ажиллагаагаа эрс идэвхжүүлж ирсэн юм.

Бандунгийн үзэл санааны үндсэн дээр тогтсон Монгол, Энэтхэгийн найрамдалт харилцаа, хамтын ажиллагаа 30 гаруй жилийн дотор амжилттай хөгжиж тус хоёр орон улс түмний энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, Азийн улсуудын хооронд харилцан ойлголцох хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөхийг хазаарлан зогсоох, дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах болон олон улсын тулгамдсан бусад олон асуудлаар нэгэн хүсэл эрмэлзлэл, ижил төстэй байр суурь баримталж байгаа нь Монгол-Энэтхэгийн уламжлалт найрамдалт харилцааны бат найдвартай үндэс суурь болж байна.⁴

Ази тивийн олон улсын байдал нэн хурцадсан өнөөгийн нөхцөлд түгшүүртэй байдлыг намжаах явдал энэ бүс нутгийн нийт улс түмний амин чухал зорилт болж байна. Энэ талаар ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев 1986 оны 1-р сарын 15 ны мэдэгдэлдээ Азийн социалист орнууд, тэрчлэн Энэтхэг болон эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүн бусад улсын дэвшүүлж байгаа оновчтой саналуудыг өндөр үнэлээд Ази тивд аюулгүй, өнө бат энх тайвны систем бүрдүүлэхэд нийтээрээ хандах иж бүрэн хандлагыг тус тивийн бүх улс орны хамтаар эрж сүвэгчилэхэд ЗХУ идэвхтэй оролцож чухал хувь нэмэр оруулахад бэлэн байгаагаа илэрхийллээ. Ази тивийн хамгийн том гүрнүүдийн нэгнийн хувьд тус тивийн энх тайван аюулгүй байдлыг хангахад ЗСБНХУ-ын роль үүрэг асар их юм. Үүний зэрэгцээ уг зорилтыг хэрэгжүүлэхэд 50-аад оны дундуур Энэтхэг улсын санаачлага, идэвхтэй оролцоотойгоор үүсч, олон улсаар хүлээн зөвшөөрөгдсөн «Панча шила», Бандунгийн арван зарчимаас эхлээд Ази тив, Номхон далайн сав газарт энх тайван тогтвортой байдлыг хангахад тус дөхөм үзүүлэхэд чиглэсэн ЗХУ, БНМАУ-ын санал, санаачлагууд, мөн Энэтхэг Хятадын хойгийн гурван улс, БНАСАУ, Энэтхэг болон Азийн бусад улсуудын бүс нутгийн тогтвортой байдлыг хангах талаар гаргасан тодорхой санал, хүчин чармайлт энэ бүгд нийлээд Азийн аюулгүй байдлын асуудалд иж бүрэн хандах хандлагыг боловсруулж хэрэгжүүлэхэд чухал үндэс суурь болох юм.

БНМАУ, БНЭУ-ын Засгийн газраас Ази тивийн энх тайван, тогтвортой байдлыг хангах, энэ бүс нутгийн улсуудын харилцаанд энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг хэрэгжүүлж, үр ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаа нь улс түмний харилцан ойлголцох, империализм, зүсэн бүрийн харгис хүчний эсрэг хийх тэмцлийн нэгдлийг хангахад чухал ач холбогдолтой юм. Энэтхэг улс Ази болон олон улсын амьдралын тулгамдсан асуудлыг зохицуулан шийдвэрлэх талаар ЗХУ, БНМАУ, социалист орнуудаас удаа дараа дэвшүүлсэн санал, санаачлагуудыг даян дэлхийн болон Ази тивийн тодорхой бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад чиглэсэн чухал алхам хэмээн үзэж ямагт дэмжиж ирсэн юм. Тухайлбал, Энэтхэгийн засгийн газар Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц боловсруулах байгуулах талаар БНМАУ-ын засгийн газрын дэвшүүлсэн саналыг⁶ хүлээн аваад ирүүлсэн хариундаа «...Монголын санаачилга бол олон нийнийн санаа бодлыг дайчлахад чухал алхам бөгөөд танай орон энх тай-

⁴ «Үнэн» 1985.12.24.

⁵ Үнэн» 1986. 1. 17.

⁶ МАХН-ын XVIII их хурлын материал УБ. 1981

ван, аюулгүй байдлын үйлсэд үнэнч байдгийн илрэл мөн»⁷ гэж үнэлсэн билээ.

Энэтхэгийн засгийн газар өнгөрсөн оны сүүлчээр Женевт ЗХУКН ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев, АНУ ын ерөнхийлөгч Р. Рейган нарын хийсэн дээд хэмээний уулзалтын үр дүнд баяр хүргэж мөн М. С. Горбачевын 1986 оны 1-р сарын 15-ны мэдэгдлийг «Даян дэлхийн энх тайван, манай гаригийг цөмийн зэвсгээс ангижруулахын төлөө тэмцлийн дээд цэг мөн»⁸ гэж үнэлжээ.

Ази тивийн энх тайван, тогтвортой байдлыг хангах тэмцэлд Энэтхэгийн далайн сав газрын хурцадмал байдлыг намжаах явдал чухал алхам болох ёстой гэж энэтхэг үздэг юм. Тиймээс ч ноён Ражив Гандийн засгийн газар Энэтхэгийн далайг цөмийн зэвсгээс чөлөөт энх тайвны бүс болгохын төлөө тууштай тэмцэл явуулахын зэрэгцээ ЗХУ, БНМАУ-ын байр суурийг дэмждэг юм. Энэтхэгийн засгийн газар Энэтхэгийн далайн бүс нутагт гадаадын цэргийн цөмийн зэвсэгтэй болон зэвсэггүй хөлөг онгоц орох явдлыг хориглох, далайн эрэг хавийн улсуудын хооронд харилцан үл довтолох, Энэтхэгийн далайн сав газарт байрлаж байгаа цөмийн зэвсгийг устгах тухай гэрээ байгуулахын төлөв, Америкийн засаг захиргаанаас Энэтхэгийн далайг цөмийн зэвсэг бүхий цэргийн түшиц газар болгож милитаричлахын эсрэг тэмцэж, Энэтхэгийн далайд цэрэг зэвсгийн үйл ажиллагааг хязгаарлах улмаар хорогдуулан цөөлөх асуудлаар ЗХУ, АНУ-ын хооронд явагдаж байсан хэлэлцээг сэргээх (энэ хэлэлцээг АНУ тасалсан юм. Д. П., Энэтхэгийн далайн асуудлаарх олон улсын бага хурлыг 1986 онд багтаан хуралдуулах болмжийг хангахын төлөө энхийг эрхэмлэгч бусад орнуудын хамт тэмцэж байгаа билээ.

Эдүгээ эгнээндээ 100 гаруй улсыг нэгтгэж, олон улсын бодлогод нөлөө бүхий хүч болсон эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд Энэтхэг улс үүсэн бий болохоос нь эхлээд идэвхтэй оролцон түүнийг империализм, колониолол, шинэ колониололын бодлогын эсрэг олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, олон улсын эдийн засгийн шударга дэг журам тогтоохын төлөө тэмцлийн гол хэрэглүүр болгоход ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа юм. Ерөнхий сайд Ражив Ганди энэ хөдөлгөөний талаар Ж. Неру, Индира Ганди нарын чиг шугамыг тууштай баримтлан эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний эгнээг бэхжүүлэх, орчин үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд түүний үйл ажиллагааг идэвхжүүлэхэд онцгой анхаарч байна. 1985 онд Аргентин, Энэтхэг, Грек, Мексик, Танзани, Швед зэрэг эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүн 6 улсын төр, засгийн газрын тэргүүн нар цөмийн зэвсэгтэй гүрнүүд болон бүх дэлхийн улс түмэн, Парламент засгийн газруудад хандаж сансрын уудамд зэвсэглэлээр хөөцөлдөхийг сэрэмжлэн зайлуулж, цөмийн зэвсгийн туршилтыг бүх нийтээр хориглох нь цөмийн зэвсгийг бүрэн устгах зорилгод хүрэх чухал алхам хэмээн үзэж энэ талаар тодорхой арга хэмжээ авахыг цөмийн зэвсэгтэй гүрнүүдэд уриалсан Делийн тунхаглал хэмээх баримт бичгийг гаргасан юм. БНМАУ-ын Засгийн газар Делийн тунхаглалын үзэл санааг бүрэн дэмжиж «...энэхүү баримт бичиг нь улс түмний энх тайван эрхийн тухай, эл эрхийг сахин хамгаалж хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх явдал бол улс гүрэн бүрийн үндсэн үүрэг мөн гэж үзсэн НҮБ-ын 39-р чуулганаас баталсан тунхаглалын заалттай бүрэн нийцэж байна»⁹ гэж үнэлсэн юм.

⁷ ГЯЯ-ны архивын материалаас

⁸ «Правда» 24 января 1986.

⁹ «Үнэн» 1985.2.7

Энэтхэгийн салбар тивийн улсуудын хоорондын харилцааг хэвийн болгож сайжруулахад Энэтхэг улс ихээхэн хүчин чармайлт тавьж байдаг бөгөөд энэ бүс нутгийн улсуудын хооронд эдийн засаг, Шинжлэх ухаан-техникийн болон бусад салбарын хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулж хөгжүүлэхэд өнгөрсөн оны сүүлчээр Бангладэшийн нийслэл Даккад болсон Энэтхэгийн салбар тивийн улсуудын дээд хэмжээний уулзалтын үеэр байгуулагдсан Өмнөд Азийн улсуудын хамтын ажиллагааны байгууллага чухал үүрэг гүйцэтгэх ёстой билээ. Энэтхэгийн Засгийн газар бүс нутгийн хамтын ажиллагааны энэ байгууллагыг зохион байгуулалтын хувьд бэхжүүлж үйл ажиллагааг нь идэвхжүүлэхэд чухал ач холбогдол өгч байна.

Империалист харгис хүчин тэдний Ази дахь холбоотнуудаас энэ тивийн тусгаар тогтносон улс орнуудыг цэрэг дайны түрэмгий бодлогодоо идэвхтэй татан оруулах зорилгоор тэдэнд улс төр, эдийн засгийн янз бүрийн даралт шахалт үзүүлж байгаа одоогийн нөхцөлд империалист бодлогын эсрэг явуулах Азийн ард түмний тэмцлийн эгнээг бэхжүүлж улмаар Ази тивийн энх тайван, аюулгүй байдлын асуудалд нийтлэг, иж бүрэн хандах хандлагыг боловсруулах арга замыг эрж сүвэгчилэхэд Энэтхэг улсын эвсэлд үл нэгдэх гадаад бодлогын үйл ажиллагаа, Ази болон олон улсын тавцан дахь Монгол, Энэтхэгийн хамтын тэмцэл чухал нэмэр хандив болох нь дамжиггүй юм.